

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зүүнбаян-Улаан сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨВА-2024/09/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Арвайхээр хот

2024 он

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com

Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг

Утас: 70323108 Цахим хаяг: Erdenetsetsegb@audit.gov.mn

Аудитор: Э.Энхбаяр

Утас: 70323833 Цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, ТТЗ-ийн нутаг дэвсгэрийн
5 дугаар байр, Арвинзур сум, Өвөрхангай аймаг, 62173
Утас/факс: (976) 7032 3253
Цахим шуудан: ovorkhangai@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Хугацаа: 2023.12.22 № 134
Тайлан № _____ -т

ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б БААСАН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Зүүнбаян-Улаан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Зүүнбаян-Улаан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Зүүнбаян-Улаан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүдийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан нь "Хязгаарлалттай" дүгнэлт өгөх үндэслэл болсон. Тухайлбал:

- Тайлант онд сумын төсвийн орлого төлөвлөснөөс 123,921.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч татварын орлогын 8 нэр төрлийн орлого 24,367.0 мянган төгрөгөөр тасарсан байна.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авсан 525 ш 17,850.0 мянган төгрөгийн бараа материалыг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант хугацаанд сумын ТТЗ-ын нийт зардлыг төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулбал 45.29 хувиар буюу 531,240.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь тайлант хугацаанд цалин, хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

017030007

Цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдал үүссэнээс сумын өвс тэжээлийн нөөцөөс малчдад хөнгөлөлттэй үнээр борлуулж, авлага үүсгэсэн байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	770,151.5	679,397.3
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,605,318.8	1,609,704.6
	Нийт хөрөнгийн дүн	2,375,470.4	2,289,101.9
	Нийт өр төлбөрийн дүн	300.0	10,919.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,375,170.4	2,278,182.9
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,375,470.4	2,289,101.9
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	2,670,536.9	1,633,794.7
	Үйл ажиллагааны зардлын дүн	2,096,181.9	1,389,478.4
	Үйл ажиллагааны үр дүн	574,354.9	244,316.3
	Үйл ажиллагааны бус үр дүн	2,968,384.1	341,303.8
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(2,394,029.1)	(96,987.5)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,035.2	15,035.2
	Тайлант оны үр дүн	(2,394,029.1)	(96,987.5)
	Эцсийн үлдэгдэл	2,375,170.4	2,278,182.9
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,368,484.2	1,474,576.6
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,947,703.3	1,150,215.7
	Үйл ажиллагааны ЦМГ	420,780.9	324,360.9
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(262,503.4)	(372,648.8)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	(81,189.2)	(51,749.4)
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	77,088.4	(100,037.4)
	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл	251,320.2	328,408.5
	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	328,408.5	228,371.1
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,172,845.5	1,539,523.3
	Урсгал зардал	850,965.4	1,146,469.9
	Хөрөнгийн зардал	240,690.9	341,303.8
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,159,288.5	1,605,290.9
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	822,912.5	1,138,460.6
	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	135,554.3	207,687.7
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	81,583.1	237,155.0
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,055.0	21,987.5
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	110,183.6	-

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Гурав. Аудитын илрүүлэлт:

Зүүнбаян-Улаан сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 17.9 сая төгрөгийн нийт 2 зөрчил¹ илэрч 2 албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт:

1. ОНХС-ын хөрөнгөөр бэлтгэсэн 525 ш 17.9 сая төгрөгийн хивэг тэжээлийг холбогдох байгууллагын бараа материалын дансанд бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

ОНХС-ын хөрөнгөөр бэлтгэсэн бараа материалыг холбогдох дансанд бүртгээгүй зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

2. Сумын 2023 оны татварын болон татварын бус орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 52.4 хувиар давж биелсэн боловч 8 нэр төрлийн орлого тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Сумын төсвийн татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө 8-н нэр төрлөөр тасарсан тул цаашид тооцоо судалгаатай, үндэслэлтэй, бодитой төлөвлөж байх албан шаардлага хүргүүлэх

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ТТЗ-ийн харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар 1 байгууллага, 3 сангийн тайланг түүвэрт хамруулж, 1 байгууллагад дүгнэлт гаргасан байна. / ЗДТГ, ИТХ, Эрсдэлээс хамгаалах сан, Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан/

Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэлээр 55.7 сая төгрөгийн 3 алдаа залруулж, 62.4 сая төгрөгийн 3 зөрчил илэрч, 2 албан шаардлага 1 зөвлөмж хүргүүлсэн байна.

Зүүнбаян-Улаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- Эхний хагас жилийн санхүүгийн тайлангаар үндсэн хөрөнгөд 1.5 сая төгрөгийн элэгдэл байгуулаагүй. /залруулсан алдаа/
- Үр дүнгийн тайланд НДШ-ийн 4.6 сая төгрөгийн зардлыг цалингийн зардал дээр тайлагнаж зардлуудыг буруу илэрхийлсэн. /залруулсан алдаа/
- Төлөөлөгчдийн үйл ажиллагааны зардлыг тэтгэмж урамшууллын зардлын эдийн засгийн ангиллаас зарцуулж 11,250.0 мянган төгрөгийг төлөөлөгч нарт бэлэн олгосон. /албан шаардлага/

Зүүнбаян-Улаан сумын Засаг даргын Тамгын газар:

- Хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээг эрх бүхий байгууллагын шийдвэрээс 49.6 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасан. /залруулсан алдаа/
- Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй. / албан шаардлага/
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, баталж мөрдөөгүй /зөвлөмж / зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Дүн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	2	17,850.0	0	0	2	17,850.0	0	0	0	0	0	0
Дүн	2	17,850.0	0	0	2	17,850.0	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
ТТЗ	0	0	0	0	0	0	0	0	0
Дүн	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн	0	0	0	0	0	0	0	0	0
Нийт дүн	2	17,850.0	0	0	2	17,850.0	0	0	0

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

